

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхэлснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон. Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон.

Аймгийн төсвийн орлогод 22.6 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 4.8 хувиар биелсэн байна.
Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 16.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 55.3 тэрбум төгрөгт хүрсэн нь 2012 оны жилийн эцсээс 8.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 30.5 тэрбум төгрөг болсон нь 2012 оны жилийн эцсээс 5.2

тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 82.7 хувь болох 822.3 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.4 хувь болох 821.5 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 97.2 мянгаар дээгүүр байна.

Малын онд оролт: Энэ онд 2280.6 мянган мал онд орж байгаа бөгөөд эхний 5 сард оны эхний малын 0.7 хувь болох 16.6 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.3 хувьтай байна.

Тариалалт: 4.8 га-д төмс, 11.3 га-д хүнсний ногоо тариалаад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс төмс 21.4 га-аар, хүнсний ногоо 2.5 га-аар тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2013 оны эхний 5-н сард 13.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.4 тэрбум төгрөг буюу 9.4 хувиар буурч харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оны үнээр 2013 оны эхний 5-н сарын байдлаар 54.5 тэрбум төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 0.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс нарийн боов, зайрмаг, яндан, том дээл, хантааз, хаалга, пийшин, шургуулга, түлээний авдар, угаалтуур, агааржуулагч, сандал үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 3.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 7.9 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 4.2 хувиар, тээвэр 3.7 хувиар, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2.0 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 8.7 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 4.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнэ тарифын ерөнхий индекс 7.8 хувиар өссөн байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 5 сард 510 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 10-н эх буюу 1,9 хувь, амьд төрсөн хүүхдийн тоо 513 болж, 13 хүүхэд буюу 2,5 хувиар буурлаа.

Халдварт өвчнөөр 582 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 279-ээр өссөний дотор гахай хавдар, салхин цэцэг, тэмбүү, сүрьеэ, заг зэрэг өвчлөлүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 863 болж урьд оны мөн үеэс 739-н хүнээр буурсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 60.4 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 18.9 хувь нь дээд, 6.6 хувь нь тусгай дунд, 41.9 хувь нь бүрэн дунд, 6.4 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 5 сард 1160 хүн шинээр бүртгүүлж, 385 хүн ажилд орсны дотор 129 нь шинэ ажлын байр байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 5 сард 123 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 25 хэрэг буюу 25,5 хувиар өсчээ. Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 47 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 343.7 сая төгрөгийн хохирол учирсны 83 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 114 хүн холбогдон сэжиглэгдсэний 35.9 хувь нь согтуугаар, 8.8 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1180 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 320 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 116 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС